



Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#7 (16)

2023 он

VII сар

Сар тутмын хэвлэл

 <http://www.mnier.mn>

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРАЛ



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ



2018-2022 он



2023-2028 он

1. Алсын хараа:

Монгол Улсын боловсролын хөгжлийн шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлж, монгол хүний хөгжилд хувь нэмэр оруулна.

Боловсролыг сайн сайхан нийгэм рүү хөтлөх судалгааны хүрээлэн байна.

2. Эрхэм зорилго:

Боловсролын судалгаагаар олон улсын түвшинд хүрсэн эрдэм шинжилгээ, арга зүйн тэргүүлэгч байгууллага байна.

Монгол Улсын боловсролын хөгжлийн шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлж, монгол хүний хөгжилд хувь нэмэр оруулна.

3. Зорилго:

1. Эрдэм шинжилгээ, боловсруулалтын үйл ажиллагааны хөгжил
2. Удирдлага, зохион байгуулалтын хөгжил
3. Хүний нөөцийн хөгжил
4. Материаллаг бааз, техник, технологийн хөгжил
5. Санхүү, эдийн засгийн хөгжил
6. Нийгмийн хариуцлагын хөгжил

1. Эрдэм судлалд түүчээлэгч
2. Боловсролын чанарыг эрхэмлэгч
3. Ёс зүйтэй түншлэгч
4. Шинийг санаачлагч
5. Хүний нөөцийг хөгжүүлэгч
6. Тогтвортой хөгжлийг дэмжигч



БСҮХ-ИЙН 2018 – 2022 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Зорилго, зорилт, үйл ажиллагаа	Тоогоор		Хувиар	
	Зорилт	Үйл ажиллагаа	Зорилт	Үйл ажиллагаа
1. Эрдэм шинжилгээ, боловсруулалтын үйл ажиллагааны хөгжлийн зорилго	8	43	34.8%	41.7%
2. Удирдлага, зохион байгуулалтын хөгжлийн зорилго	4	17	17.4%	16.5%
3. Хүний нөөцийн хөгжлийн зорилго	3	7	13.0%	6.8%
4. Материаллаг бааз, техник, технологийн хөгжлийн зорилго	2	6	8.7%	5.8%
5. Санхүү, эдийн засгийн хөгжлийн зорилго	3	11	13.0%	10.7%
6. Нийгмийн хариуцлагын хөгжлийн зорилго	3	19	13.0%	18.4%
Бүгд	23	103	100.0%	100.0%

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЕЛЭЛТ

Зорилго	Зорилт	Үйл ажиллагаа			Үйл ажиллагаа		
		Төлөвлөсөн	Биелсэн	Биелээгүй	Төлөвлөсөн	Биелсэн	Биелээгүй
1. Эрдэм шинжилгээ, боловсруулалтын үйл ажиллагааны хөгжлийн зорилго	8	43	26	17	41.7%	60.5%	39.5%
2. Удирдлага, зохион байгуулалтын хөгжлийн зорилго	4	17	2	15	16.5%	11.8%	88.2%
3. Хүний нөөцийн хөгжлийн зорилго	3	7	2	5	6.8%	28.6%	71.4%
4. Материаллаг бааз, техник, технологийн хөгжлийн зорилго	2	6	2	4	5.8%	33.3%	66.7%
5. Санхүү, эдийн засгийн хөгжлийн зорилго	3	11	4	7	10.7%	36.4%	63.6%
6. Нийгмийн хариуцлагын хөгжлийн зорилго	3	19	12	7	18.4%	63.2%	36.8%
Бүгд	23	103	48	55	100.0%	39.0%	61.0%
Дундаж	3.8	17.2	8	9.2	17.0%	6.0%	10.0%

БСҮХ-ИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2023 - 2028)

1. Алсын хараа:	Боловсролыг сайн сайхан нийгэм рүү хөтлөх судалгааны хүрээлэн байна.
2. Эрхэм зорилго:	Монгол Улсын боловсролын хөгжлийн шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлж, монгол хүний хөгжилд хувь нэмэр оруулна
3. Үнэт зүйл:	<ol style="list-style-type: none"> 1. Чанартай судалгаа 2. Судалгааны ур чадвар, чадавх 3. Туршлага 4. Хүмүүнлэг, хамтын ажиллагаа 5. Мэдлэгт суурилсан шинжлэх ухаанч хандлага
4. Зарчим:	<ol style="list-style-type: none"> 1. Шинжлэх ухаанч байх 2. Хүмүүнлэг байх 3. Чанартай, үр ашигтай байх
5. Зорилго:	<ol style="list-style-type: none"> 1. Эрдэм судлалд түүчээлэгч 2. Бүтээгдэхүүний чанарыг эрхэмлэгч 3. Ёс зүйтэй түншлэгч 4. Шинийг санаачлагч 5. Хүний нөөцийг хөгжүүлэгч 6. Тогтвортой хөгжлийг дэмжигч
6. Зорилт:	
7. Үйл ажиллагаа:	


БСҮХ-ИЙН ИРЭЭДҮЙН 5 ЖИЛИЙН ДҮР ТӨРХ



БСҮХ-ИЙН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (58 АЖИЛ)

№		ЭШ, боловсруулалтын үйл ажиллагааг хөгжүүлэх			Удирдлага, зохион байгуулалт	Хүний нөөцийн хөгжил	Материал лаг бааз, техник технологийн хөгжил	Санхүү, хөрөнгө оруулалтын хөгжил	Нийгмийн хариуцлагын хөгжил	НИЙТ
		Судалгааны ажил	Арга зүйн ажил	Чанар сайжруулах хэвлэн нийтлэх	Харилцаа хамтын ажиллагаа					
1	Боловсролын бодлого, төлөвлөлтийн судалгааны сектор	2	1							3
2	Боловсролын хөгжлийн ирээдүй судлалын судалгааны сектор	3	2							5
3	Боловсролын эдийн засаг, менежментийн судалгааны сектор	1								1
4	Өгөгдөл боловсруулалт, цахим судалгаа хөгжүүлэлтийн сектор		1		2	1	1			5
5	Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, сурах бичгийн судалгааны сектор	7	11						1	19
6	Хүний хөгжлийн судалгааны сектор	2	2							4
7.	Захирал					2				
8.	Эрдэмтэн нарийн бичгийн дарга	1	2	1				1		5
9.	Гадаад харилцаа, хамтын ажиллагаа, эрх зүй, олон нийттэй харилцах алба								4	4
10.	Дэмжих үйлчилгээний алба					2		1	1	4
11.	Монгол хэл бичгийн судалгаа арга зүйн төв	2	2							4
12.	Гадаад хэлний төв		2							2
13.	ТХБ-ын судлаачид									
	Нийт	18	23	1	2	5	1	2	6	58

БСҮХ-ИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН БИЕЛЭЛТИЙН ПРОЦЕССИЙН ЗУРАГЛАЛ



БСҮХ-ИЙН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДИЗАЙН

№	Ажлын нэр	5 сар					6 сар - 10 сар					11 сар					12 сар				
		I	II	III	IV	V	I	II	III	IV	V	I	II	III	IV	V	I	II	III	IV	V
1	ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, БОЛОВСРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖИЛ																				
1.1	Судалгааны чиглэлийн үйл ажиллагааг хөгжүүлэх																				
1.1.1	“Хувьсаж буй боловсрол”-ын үндэсний амлалт бичигт тусгагдсан амлалтуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, зураглал боловсруулж батлуулна.																				
1.2	Арга зүйн чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх																				
1.2.1	Насанд хүрэгчдийн боловсролын хөтөлбөрийн төсөл боловсруулна																				
1.3	Эрдэм шинжилгээний бүтээлийн чанарыг сайжруулах, хэвлэн нийтлэх үйл ажиллагааг тогтмолжуулах																				
1.3.1	Эрдэм шинжилгээний семинар, хурал зохион байгуулна, оролцоно.																				
2	УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО																				
2.2	Харилцаа, хамтын ажиллагааны менежментийг сайжруулах																				
2.2.1	Боловсролын дата төвд БСҮХ-ийг серверүүдийг байрлуулна.																				
3	ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО																				
3.1	Эрдэм шинжилгээний ажилтныг хөгжүүлэх, суралцагч байгууллагыг төлөвшүүлэх																				
3.1.1	БСҮХ-ийн докторант ЭША-д зөвлөн тусална																				
4	МАТЕРИАЛЛАГ БААЗ, ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО																				
4.1	ЭША-уудын ажиллах нөхцөлийг сайжруулах																				
4.1.1	ЭША-нуудын албан хэрэгцээний компьютерыг өргөн болон тусгай хэрэглээний лицензтэй программ хангамжаар тоноглоно.																				
5	САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО																				
5.1	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах																				
5.1.1	Судлаачдын бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бий болгоно.																				
6	НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО																				
6.1	Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулж, нийгмийн хариуцлагын сан үүсгэж, ашиглах																				
6.1.1	Боловсролын байгууллага, иргэд, олон нийтийг судалгааны мэдээллээр хангана.																				
6.2	Ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, сайн сайхны төлөө анхаарч ажиллах																				
6.2.1	Ажилтнуудын эрүүл мэнд, аялал, спортын арга хэмжээг төлөвлөж, зохион байгуулна.																				
6.3	Нийгэм, олон нийтийг соён гэгээрүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах																				
6.3.1	Телевиз, мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллаж, нийгэм, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.																				

БСҮХ-ИЙН 2023 ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ



2023 ОНД ЗАХИРЛЫН МАНЛАЙЛЛААР ХИЙХ ОНЦЛОХ 5 АЖИЛ

- 1 БСҮХ-ийн стратеги төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж эхлэх
- 2 Монгол улсын боловсролыг 2030 хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал
- 3 “Монгол суралцагч 2030”
- 4 СӨБ болон ЕБ-ын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал
- 5 Боловсролын судалгааны Монголын сэтгүүлийн 5 жилийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх

“КОМПЬЮТЕРЫН ШИНЖЛЭХ УХААН, КОМПЬЮТЕРЫН ИНЖЕНЕРЧЛЭЛ БОЛОН БОЛОВСРОЛЫН ТЕХНОЛОГИ” ОЛОН УЛСЫН СИМПОЗИУМ (ISCSET -2023)



“Компьютерын шинжлэх ухаан, компьютерын инженерчлэл болон боловсролын технологи” олон улсын симпозиумыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн Хемнецийн ТИС болон бусад таван байгууллагатай сүүлийн 3 жил хамтран зохион байгуулж байна.



<https://www.iscset-conf.org/>

Олон улсын симпозиум (ISCSET) нь 2011 онд хоёр их сургуулийн зуны сургуулиар эхэлсэн бөгөөд жилээс жилд энэ арга хэмжээнд илүү олон их, дээд сургуулиуд хамрагдаж, 2014 онд Монгол, Герман, Орос, Хятад улсын их дээд сургуулиудын хооронд хамтын ажиллагаа бий болж симпозиумын түвшинд хүртэл өргөжсөн.

Харин өнөөдрийн байдлаар тус Олон улсын симпозиумыг зохион байгуулахаар дараах байгууллагууд хамтран ажиллаж байна.

- Хемнецийн Техникийн Их Сургууль (ХБНГУ)
- ШУТИС (Монгол)
- Новосибирск хотын Улсын Техникийн Их Сургууль (ОХУ)
- Харбины Технологийн Их Сургууль (БНХАУ)
- Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн (Монгол)
- Л.Н.Гумилевийн нэрэмжит Евразийн их сургууль (Бүгд Найрамдах Казахстан Улс)
- Бухар хотын Улсын Их Сургууль (Бүгд Найрамдах Узбекистан Улс)



Шинжлэх Ухаан
Технологийн
Их Сургууль



Новосибирский
государственный
технический
университет



ISCSET нь Компьютерын шинжлэх ухаан, компьютерын инженерчлэл, боловсролын технологи гэсэн гурван үндсэн чиглэлийг хамардаг. Сүүлийн хорин жилд технологи хурдацтай хөгжиж, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн бүх салбарт янз бүрийн технологийг ашиглах боломжийг олгосон. Үүнтэй холбогдуулан, сургалтын үйл явцад олон өөрчлөлт гарсан. Технологийн хөгжлийг дэмжихийн тулд маш сайн инженер, эрдэмтэд хэрэгтэй.



“Иймд дээд боловсрол тэр дундаа инженерийн боловсрол сургалтын үйл ажиллагаанд орчин үеийн арга, технологийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Бидний харж байгаагаар дээрх гурван чиглэл нь дээр дурдсан асуудлуудад маш чухал бөгөөд эдгээр чиглэлээр хэрэгжиж буй төсөл, ирээдүйн чиг хандлагыг тусгахыг зорьж байна” гэж хурлын зохион байгуулагч нар тэмдэглэж байна.

Энэ 12 дахь удаагийн “ISCSET-2023” нь 2023 оны 07 сарын 05-07-ны хооронд ХБНГУ-д “Internationales Informatik- und Begegnungszentrum Sachsen (IBS)” сангийн дэмжлэгтэйгээр цахим болон танхимаар зохион байгуулагдсан.

Тус симпозиумд ХБНГУ, Франц, БНХАУ, Монгол, ОХУ, Йордан, Алжир, Япон, Казахстан, Бүгд Найрамдах Узбекистан Улсын эрдэмтэд судлаачид

боловсролын хөгжлийн шинэ чиг хандлага болох компьютерын инженерчлэл, боловсролын технологи, цахим шилжилтийн асуудлуудыг шүүн хэлэлцэж, улмаар хүн төрөлхтний өмнө тулгарч байгаа шинэ бэрхшээлүүдийг даван туулах гарцыг нээхэд хувь нэмэр оруулсан болно.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн Монгол Улсын цахим шилжилт, суралцагчдын цахим сургалтын бэлэн байдал, иргэдийн цахим ур чадварын өнөөгийн байдал болон бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийн бүтцийн хүрээг судалж симпозиум дээр хэлэлцүүлж, хянан магадлалтай сэтгүүлд судалгааны дараах өгүүллүүдийг хэвлүүлсэн:

- A competency framework implementation for international public in the information, communication and technology
- Some results of the study on determining digital competence needs of citizens
- A study for the development needs of professional teachers at vocational education and training institution in Mongolia
- First-year students' satisfaction by e-learning (On the example of School of Nursing)



“Компьютерын шинжлэх ухаан, компьютерын инженерчлэл болон боловсролын технологи” олон улсын симпозиум (ISCSET-2023)-ын эмхэтгэлийг QR уншуулан үзэх боломжтой.

Дашрамд дурдахад тус олон улсын симпозиум нь ирэх жил IEEE хурал болж явагдах эрхээ авсан байна.